



ДУНДГОВЬ АЙМАГ
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 4/37

Тавин

Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/34 дүгээр тушаал, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын 14-ны өдрийн А/222 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийн устгал, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн арга хэмжээг 2023 оны 05 сарын 01-ээс эхлэн сарын хугацаатай зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Цолмонбаатар (Мал эмнэлгийн тасгийн малын эмч, тархвар зүйч)

Гишүүд: Э.Ариунбилэг (Байгаль орчны байцаагч)
О.Ганбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Ж.Батжаргал (1 дүгээр багийн Засаг дарга)
Ю.Туяамаа (2 дугаар багийн Засаг дарга)
Б.Төмөрчөдөр (3 дугаар багийн Засаг дарга)
Э.Сэржмядаг (4 дүгээр багийн Засаг дарга)
Ё.Адилбиш (5 дугаар багийн Засаг дарга)

2. Цаг агаарын нөхцөл байдал салхи шуурганы үеийн байдлаас шалтгаалан зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг байгаль орчин бохирдуулахаас сэргийлж хороо, бууц, худаг уст цэг, бэлчээрээс цуглуулж зориулалтын цэгт булж,

устгах халдваргүйтгэх арга хэмжээг зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах ажлын хэсэгт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Марал-Үжин)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.УРАНЧИМЭГ